

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн
2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/16/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Менежментийн захидал.....	13
3.1	Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал.....	13
3.1.1	Илрүүлэлт:.....	13
3.1.2	Эрсдэл:.....	13
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	14
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	16
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	18
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	21
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.БАЯРЦОГТ
ТАНАА

2018.03.20 № 06/507
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 2019 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, ахлах аудитор Б.Цогзолмаа,

О.Цэндхүү, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, аудитор М.Батмагнай, аудиторын туслах М.Сэржмядаг, Д.Эрдэнэбаяр, Т.Алтанчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/78 дугаар албан бичгээр Мишээл-Од Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрчим хүчний салбарыг арилжааны хэлбэрт шилжүүлэх, хувьчлах хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 164 дүгээр тогтоолын дагуу 2001 оны 8 дугаар сарын 1-ний өдөр “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нэртэйгээр зохион байгуулагдсан байна.

Эрхэм зорилго:

“Бид найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчийг түгээхдээ хэрэглэгчээ хүндэлж, нийгмийн хариуцлагыг эрхэмлэн, аюулгүй ажиллагааг ханган ажиллана” гэсэн эрхэм зорилгын хүрээнд Монгол Улсын нийт 11 аймгийн 124 сум суурин газрын 76,613

хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг түгээх, хангах үйл ажиллагааг 35, 15, 10, 6, 0.4 кВТ-ын 5,970.6 км дамжуулах шугам сүлжээ, төрийн эзэмшлийн 623, хувийн болон бусдын эзэмшлийн 655, нийт 1,278 дэд станц, хуваарилах байгууламжийг ашиглан Булган, Архангай, Өвөрхангай, Хархорин гэсэн 4 салбартай үйл ажиллагаагаа явуулж байна.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК дараах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч түгээх
- Цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил үйлчилгээ эрхлэх /0,4-35кВт хүртэл/
- Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах /0,4-35кВт хүртэл/
- Монгол Улсад зөвшөөрөгдсөн загварын цахилгаан эрчим хүчний 1 ба 3 фазын механик, электрон, импульсийн тоолуур гүйдлийн трансформатор засварлах, тохируулах, суурилуулах, худалдах
- Цахилгаанчин давтан мэргэшүүлэх сургалт явуулах
- ХАБЭА-н сургалт зохион байгуулах

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Нийгмийн даатгалын тухай хуульд ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 1 хувиар нэмэгдүүлсэн. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан татварын шатлалын өөрчлөлтийг мөрдөж байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 20 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 20 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгов.

Энэ нь тус байгууллагын хувьд үйлчилгээ үзүүлэх зорилготой төрийн байгууллага тул үйл ажиллагааны орлого нь үйл ажиллагааны цар хүрээг илтгэх хамгийн тохиромжтой үзүүлэлт гэж үнэлсэнтэй холбоотой юм.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого нь 220,509.5 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 2,205.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тус хорооны үйл ажиллагааны цар хүрээ, үйл ажиллагааны орлогын бүрдэлт, зарцуулалтад эрсдэл дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 29 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 24 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 383.5 сая төгрөгийн 6 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Дахин үнэлгээний нэмэгдэл, бууралтыг журамд тусгагдсан холбогдох дансдуудад бүртгэлгүй зөрүү дүнгээр хуримтлагдсан ашиг дансанд бүртгэж, өмчийн өөрчлөлтийн тайлангийн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт толилуулсан;
- Нийт 74.2 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг данснаас хассаныг Эздийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэсэн;
- Нийт 138.0 сая төгрөгийн хөрөнгийг 2017 онд хүлээн авч гэрээний хугацаа дуусч, төлбөрийг бүрэн шилжүүлсэн боловч гүйцэтгэл дутуу шалтгаанаар үндсэн хөрөнгөөр бүртгээгүй дуусаагүй барилга дансанд бүртгэсэн;

- Гэрээнд заасан хугацаанд ажлаа гүйцэтгээгүй 3 харилцагчтай холбоотой 22.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл он дамжин бүртгэлтэй байсан;
- Урьдчилж орсон орлого дансанд 4.9 сая төгрөгийн барьцаа төлбөр бүртгэсэн, 40.4 сая төгрөгийн хэрэгжсэн орлогыг борлуулалтаар бүртгээгүй;
- Бараа материалын зардалд тооцож бүртгэх 103.5 сая төгрөгийн бараа материалыг данснаас хасаагүй;

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	144.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	14.7	
3	Албан шаардлага өгсөн	1	266.0	
	Дүн	4	425.4	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Тайлант оны эцэст бэлтгэн нийлүүлэгчид болон хувь хүнтэй холбоотой 44 харилцагчийн 128.2 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний борлуулалттай холбоотой 179 харилцагчийн 112.3 сая төгрөг, нийт 240.5 сая төгрөгийн авлага, 1 харилцагчтай холбоотой 25.5 сая төгрөгийн өр төлбөр, нийт 266.0 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна

Шийдэл: Албан шаардлага хүргүүлэх

Асуудал 2: Худалдан авалттай холбоотой асуудал

Шатахууны тендерт заасан гэрээний үнээс өндөр үнээр худалдан авалт хийснээс 11.3 сая төгрөгийг НИК-ийн харъяа Орхон салбарт илүү шилжүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т “Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараахь тохиолдолд тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно”, 40.4.2-т “суурь үнэ огцом өөрчлөгдсөн гэсэн заалтын дагуу барааны үнэд тохируулга хийхээр гэрээнд заагаагүй нөхцөлд гэрээний үнээр худалдан авалт хийнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоох

Асуудал 3: Цалин хөлс данстай холбоотой асуудал

Ээлжийн амралтын тооцоог журамд зааснаас зөрүүтэй тооцсоноос 20 ажилтанд 2.2 сая төгрөг, цалин хасах арга хэмжээ авах тушаал гарсан боловч цалингаас суутгаагүй 1 ажилтанд 0.2 сая төгрөг, сахилгын арга хэмжээ авагдсан 4 ажилтанд 0.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зэргээр нийт 3.4 сая төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдэл: Төлбөрийн акт тогтоох

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, НББОУС, СТОУС, Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тус байгууллагын харъяа 11 аймгийн 124 сум, суурин газарт байрлалтай 2,574.7 сая төгрөгийн 184,711.92 м.кв талбайтай 547 газрын эзэмших эрхийг баталгаажуулан, кадастрийн нэгдсэн санд бүртгүүлж, 54 газрын гэрчилгээг гаргуулах шатанд, газрын албанд хүсэлт хүргүүлсэн байна.

Компанийн харъяа 77 барилгаас 22 барилгыг үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээгүй, зуслангийн барилгууд тул үнэлэх шаардлагагүй гэж үзэн 13,706.85 м.кв талбайтай 3,649.4 сая төгрөгийн 55 барилга, 5,986,813.3 метр урттай 1750 ширхэг 101,647.4 сая төгрөгийн байгууламж, 21 нийтийн эзэмшлийн байгууламж дахин үнэлгээнд хамруулсан. Хөрөнгийн дахин үнэлгээний талаарх асуудлыг дараагийн аудитаар дахин хянах нь зүйтэй гэж үзсэн.

Тус компанийн санхүүгийн програм нь хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн зөрүүг холбогдох мэдээллийг үндэслэн тооцоолдог бөгөөд тус тооцоолол үнэн зөв илэрхийлэгдэж байгаа эсэхийг дараагийн аудитаар дахин хянана.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2016 оны 07 дугаар тогтоолоор 82,251.7 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг компанийн эздийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхээр шийдвэр гаргаж бүртгэлд тусгуулсан байна. Үүнийг 2019 онд төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлсэн эсэхийг хянана.

Сангийн яамтай хийсэн Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр Дэлхийн банкны санхүүжилтээр 16,187,000 ам долларын “Эрчим хүчний төсөл-2” төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал 2018 оны 6 сараас хойш 120,681.74 ам доллар, түүнд ногдох зээлийн хүүгийн зардал 731 ам доллар байхад ашиглаагүй зээлийн үлдэгдэлд ногдох хүүгийн өр 51,586.64 ам доллар байна.

2.10. Зорилтот түвшингийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар удирдлага нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 2018 оны төлөвлөгөөг батлуулан ажилласан байна. 2018 онд 1,174.2 сая кВтц цахилгаан эрчим хүч худалдан авч 217,728.8 сая төгрөгийн орлого олж 217,613.6 сая төгрөгийн зардал гаргаж 115.2 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,185.4 сая кВтц цахилгаан эрчим хүч худалдан авч 220,509.7 сая төгрөгийн орлоготой 220,241.5 сая төгрөгийн зардалтай 268.0 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчнээс 76.5 хувийг Эрдэнэт үйлдвэр ХХК эзэлж байна. Цахилгаан эрчим хүч түгээлтийн алдагдлыг 1.8 хувиар бууруулан ажилласан. Тайлант онд хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалд 7,368.0 сая төгрөг зарцуулан 191 ажил хийхээр төлөвлөснөөс 190 ажил хийгдэж 98.9 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж 6,313.3 сая төгрөг зарцуулж, 1,054.7 сая төгрөгийг хэмнэж ажилласан.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулахад тус компани нь <https://shilendans.gov.mn/org/5235> цахим хуудсанд шилэн дансны мэдээллийг байршуулсан. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 62 мэдээллийг хуулийн дагуу бүрэн байршуулсан.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100.0 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

- 3.1.1.1 Дахин үнэлгээнд хамрагдах 2,574.7 сая төгрөгийн 184,711.92 м.кв 547 газрын газар эзэмших эрхийг баталгаажуулан, кадастрийн нэгдсэн санд бүртгүүлж, 54 газрын гэрчилгээ гараагүйгээс дахин үнэлгээнд хамрагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалттай нийцэхгүй байна.

- 3.1.1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 35 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд түншлэгчээр оролцож 144.7 сая төгрөгийн өртгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн. Тус ажил 2017 онд дуусч хөрөнгийг улсын комисст хүлээлгэн өгч, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа боловч үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалын 2.2.1-т “Үндсэн хөрөнгө хэсгийн 5-т Барилга, байгууламжийг өөрөө барьж байгуулж байгаа тохиолдолд

холбогдох өртгийг Дуусаагүй барилга дансанд хуримтлуулна. Харин барилгын ажил дуусч, мэргэжлийн байгууллагаас ашиглах зөвшөөрөл авсан бол дуусаагүй барилгаа үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлж бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайланд хөрөнгө дутуу тусгагдах
- Хөрөнгийн эзэмших эрхийг гаргуулан аваагүйгээс хөрөнгө алдагдах
- Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлыг бүртгэлд тусгахгүйгээс үлдэгдэл өртөг болон ашиг алдагдал буруу илэрхийлэгдэх,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

- Гэрчилгээ гараагүй 54 газрын гэрчилгээг гаргуулан авч бүртгэлд тусгах,
- Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 35 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг үндсэн хөрөнгөнд орлого авч, элэгдлийг өртөгт шингээх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

- 2019 оны эхний хагас жилд багтаан 54 газрыг кадастаржуулан, газар эзэмших эрхийг баталгаажуулна.
- 2014 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Баянлиг-Шинэжинст сумын ЦДАШ-ын утас татах ажил, газардуулгын ажлын хөлс манай компаниас гарсан, Улсын комисс хүлээн авч, манай компанийн ашиглалтанд өгсөн боловч гүйцэтгэгч олдохгүй, захиалагч, гүйцэтгэгчийн маргаантай асуудлаас хөрөнгийг орлогод авах шийдвэрийг гаргаж өгөөгүй, 2019 оны 4 дүгээр сарын хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлж, хөрөнгөнд бүртгэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,741,044,614.68	3,624,423,589.78
1.1.2	Дансны авлага	12,810,892,099.86	12,200,617,639.08
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	39,667,222.69	14,078,239.39
1.1.4	Бусад авлага		135,337,888.19
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,005,309,837.99	2,473,655,185.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	81,794,526.44	449,180,771.64
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	19,678,708,301.66	18,897,293,313.47
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	118,435,937,272.17	115,295,925,270.93
1.2.2	Биет бус хөрөнгө	117,175,681.67	2,655,792,997.27
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	191,139,825.30	167,656,396.08
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	118,744,252,779.14	118,119,374,664.28
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	138,422,961,080.80	137,016,667,977.75
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	14,598,800,888.18	12,252,880,385.03
2.1.1.2	Цалингийн өглөг		12,348,975.58
2.1.1.3	Татварын өр	103,745,324.53	195,063,229.76
2.1.1.4	НДШ–ийн өглөг		

2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		138,271,337.11
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	303,303,556.71	209,912,293.42
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	31,225,648.38	51,900,749.88
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	15,037,075,417.80	12,860,376,970.78
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		359,321,999.10
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	387,807,383.71	409,587,934.86
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	2,726,900,152.03	4,024,175,091.50
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,114,707,535.74	4,793,085,025.46
2.2	Өр төлбөрийн нийт дүн	18,151,782,953.54	17,653,461,996.24
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	119,534,968,376.11	119,534,968,376.11
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		2,574,667,240.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	736,209,751.15	-2,746,429,634.60
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	120,271,178,127.26	119,363,205,981.51
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	138,422,961,080.80	137,016,667,977.75

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	201,488,512,798.88	219,174,650,151.06
2	Борлуулалтын өртөг	179,588,241,617.54	208,732,097,538.72
3	Нийт ашиг(алдагдал)	21,900,271,181.34	10,442,552,612.34
4	Түрээсийн орлого		21,600,000.00
5	Хүүгийн орлого	422,310,118.13	379,945,299.42
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	832,234,076.98	932,305,688.51
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,263,996,738.16	4,076,901,812.23
10	Ерөнхий ба удирдлагын зардал	18,440,749,394.03	6,801,909,443.58
11	Санхүүгийн зардал		3,479,946.84
12	Бусад зардал	290,991,921.79	535,452,296.71
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-124,618.86	-9,896,480.45
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,727,166.72	-80,690,909.24
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	161,679,870.33	268,072,711.22
19	Орлогын татварын зардал	44,042,419.07	59,775,081.09
20	Татварын дараах ашиг (алдагдал)	117,637,451.26	208,297,630.13
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	117,637,451.26	208,297,630.13
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	117,637,451.26	208,297,630.13
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	119,534,968,376.11	0	0	639,454,669.89	120,174,423,046.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0
Залруулсан үлдэгдэл	119,534,968,376.11		0	639,454,669.89	120,174,423,046.00
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				117,637,451.26	117,637,451.26
Бусад дэлгэрэнгүй орлого					0
Өмчид гарсан өөрчлөлт					0
Зарласан ногдол ашиг				20,882,370.00	-20,882,370.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					0
2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	119,534,968,376.11		0	736,209,751.15	120,271,178,127.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-3,679,173,255.88	-3,679,173,255.88
Залруулсан үлдэгдэл	119,534,968,376.11		0	-2,942,963,504.73	116,592,004,871.38
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			0	208,297,630.13	208,297,630.13
Бусад дэлгэрэнгүй					0.00

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

орлого					
Өмчид гарсан өөрчлөлт			2,574,667,240.00		2,574,667,240.00
Зарласан ногдол ашиг				11,763,760.00	11,763,760.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					0.00
2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	119,534,968,376.11		2,574,667,240.00	-2,746,429,634.60	119,363,205,981.51

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	203,460,467,237.48	220,455,233,581.50
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	201,656,584,189.19	218,358,350,783.23
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,400,490.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,801,482,558.29	2,096,882,798.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	197,559,634,698.16	217,752,726,558.58
1.2.1	Ажиллагчдад төлсөн	7,753,504,313.87	8,737,386,326.47
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,117,007,102.29	2,496,060,786.71
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	180,483,369,210.78	199,113,050,316.37
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	96,375,988.71	81,489,126.69
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,126,894,147.04	1,403,018,561.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		8,515,471.20
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,015,236,011.90	2,829,724,718.25
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,725,395.70	9,444,827.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,958,522,527.87	3,074,036,424.89
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,900,832,539.32	2,702,507,022.92
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	415,795,308.42	379,945,299.42
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	415,795,308.42	379,945,299.42
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,656,011,644.61	4,176,399,716.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,569,611,644.61	4,176,399,716.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	86,400,000.00	

2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,240,216,336.19	-3,796,454,416.58
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,882,370.00	23,501,366.80
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		11,737,606.80
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	20,882,370.00	11,763,760.00
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-20,882,370.00	-23,501,366.80
4	Валютын ханшийн зөрүү	(124,618.86)	827,735.56
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	639,609,214.27	-1,116,621,024.90
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,101,435,400.41	4,741,044,614.68
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,741,044,614.68	3,624,423,589.78

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019.03.15	Аудитын нэр:	2018 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2019/16/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:	“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	Сая төгрөгөөр
------------------------------	--	---------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	<p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын 35 Кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд түншлэгчээр оролцож 144.7 сая төгрөгийн өртгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн. Тус ажил 2017 онд дуусч хөрөнгийг улсын комисст хүлээлгэн өгч, үйл ажиллагаандаа ашиглаж байгаа боловч үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.</p> <p>Дахин үнэлгээнд хамрагдах 2,574,7 сая төгрөгийн 184,711.92 м.кв 547 газрын газар эзэмших эрхийг баталгаажуулан, кадастрийн нэгдсэн санд бүртгүүлж, 54 газрын гэрчилгээ гараагүйгээс дахин үнэлгээнд хамрагдаагүй байна</p>	144.7	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярцогт Б.Наранцэцэг
2	<p>Насжилт өндөртэй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, төлөгдөх эсэх нь тодорхойгүй бэлтгэн нийлүүлэгчид болон хувь хүнтэй холбоотой 44 харилцагчийн 128.2 сая төгрөг, цахилгаан эрчим хүчний борлуулалттай холбоотой 179 харилцагчийн 112.3 сая төгрөг нийт 240.5 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Мөн 2014 онд үүссэн тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй 1 харилцагчтай холбоотой 25.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.</p>	266.0	Албан шаардлага өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярцогт Б.Наранцэцэг

3	Компанийн 20 ажилтныг цалин хөлсний олголтод аудит гүйцэтгэхэд ээлжийн амралтын тооцоог бодохдоо 20 ажилтанд 2.2 сая төгрөг, цалин хасах арга хэмжээ авагдсан 1 ажилтанд 0.2 сая төгрөг, сахилгын арга хэмжээ авагдсан 4 ажилтанд үр дүнгийн 0.9 сая төгрөгийн урамшуулал олгосон зэргээр бүгд 3.4 сая төгрөгийг илүү олгосон байна.	3.4	Төлбөрийн акт тогтоох	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярцогт Б.Наранцэцэг
4	Шатахууны тендерт заасан гэрээний үнээс өндөр үнээр худалдан авалт хийснээс 11.3 сая төгрөгийг НИК-ийн харьяа Орхон салбарт илүү шилжүүлсэн байна.	11.3	Төлбөрийн акт тогтоох	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Баярцогт Б.Наранцэцэг
	Нийт дүн	425.4			